

# МОНГОЛ СУДЛАЛ:

## ДЭМЖИХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д.Заяабаатар (Монгол Улс)

“Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол судлалыг дэмжих сан байгуулагдаж, УИХ-ын тогтоолоор Ерөнхий сайдын дэргэд Монгол судлалын үндэсний зөвлөлийг байгуулсан явдал монгол судлалыг эрчимтэй хөгжүүлэх чухал алхам болсон билээ. Энэхүү илтгэлд сүүлийн жилүүдэд Монгол улсаас монгол судлалыг дэмжих чиглэлээр явуулж буй бодлого, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг товч танилцуулах болно.

2014 оноос хойш монгол судлалыг хөгжүүлэх чиглэлд гарсан бодлогын шийдвэр, түүнийг дагалдсан үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд дараах эерэг хандлага гарсан гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол судлалын бодлогыг тодорхойлох (Монгол судлалын үндэсний зөвлөл), санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага (Монгол судлалыг дэмжих сан) бий болж, тэдгээрийн чиг үүргийг зохицуулах эрхзүйн баримт бичгүүд (Монгол судлалын үндэсний зөвлөлийн дүрэм, Монгол судлалыг дэмжих сангийн дүрэм) гарснаар монгол судлалын зохион байгуулалтын асуудал цэгцтэй болсон.

2. Дэлхийн монгол судлалын төвүүд, эрдэмтэн судлаачид сургалт, эрдэм шинжилгээний ажлаа дэмжүүлэх нөхцөл боломж бүрдсэнээр зарим их сургуульд монгол судлалын төв шинээр нээх, дахин сэргээх зэргээр монгол судлалын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажиллах болсон.

3. Монгол судлалын салбарт суралцаж буй гадаадын залуу судлаачдын идэвх сэргэж, энэ чиглэлийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болсноор монгол судлаачдын залуу халаа бэхжих зөв суурь бүрэлдсэн.

4. Үндэсний хэмжээний, эрдэм шинжилгээний байгууллага болон эрдэмтдийн хамтарсан суурь судалгааны томоохон бүтээлүүд хэвлэгдсэн.

5. Монгол судлалын бүтээл, эрдэм шинжилгээний хуралд тавих шалгуурыг өндөрсгөж, зохих шаардлагыг хангасан бүтээл, хуралд санхүүгийн дэмжлэг олгодог болсноор энэ чиглэлийн ажилд чанарын ахиц гарсан.

6. Монгол судлалын үйл ажиллагаа нэгдмэл зохион байгуулалтад орж, гадаад дотоодын сургалт судалгааны байгууллага, судлаачид хүчээ нэгтгэж томоохон бүтээл туурвих, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад анхаарах болсон.

7. Гадаадын монгол судлалын төвүүдийн үйл ажиллагаа бэхжих, байр сууриа хадгалахад Монгол Улсын төрөөс хэрэгжүүлж буй монгол судлалыг дэмжих бодлого тодорхой түлхэц өгсөн.

8. Монгол судлалыг хөгжүүлэх бодлого чиг баримжаатай болж, цаашид энэ чиглэлийн үйл ажиллагааг улам эрчимжүүлэх боломж нөхцөл бүрдсэн.

D. ザヤールバートル（モンゴル国）

「モンゴル研究発展の国家計画」を実行する分野でモンゴル国大統領令によってモンゴル研究支援基金が創立され、国会決議によって総理大臣附属のモンゴル研究国家委員会が開設されたことは、モンゴル研究を強力に発展させる重要な一歩となった。この報告で、近年モンゴル国がモンゴル研究を支援する方向で行っている施策と、行った活動を簡単に紹介する。

2014年以降、モンゴル研究を発展させる方面に生じた施策の決定と、それに伴う活動実施の結果、以下の好ましい傾向が生じたと見ている。

1. モンゴル研究施策を明確化する機関（モンゴル研究国家委員会）と、予算化と活動を実行する機関（モンゴル研究支援基金）が誕生し、それらの職務を調整する法的文書（モンゴル研究国家委員会規則、モンゴル研究支援基金規則）が発効したことにより、モンゴル研究の組織面の問題が整理された。
2. 世界のモンゴル研究機関と研究者に対して研修や学術活動を支援させる機会が生じたことにより、いくつかの大学にモンゴル研究機関が新たに開設・復活するなどモンゴル研究活動を強化する方向で積極的に活動するようになった。
3. モンゴル研究分野で学んでいる外国の若手研究者の積極性を回復し、この方面の研修と研究活動に積極的に参加するようになったことにより、モンゴル研究者の世代交代を強化する基盤が整った。
4. 国家規模で学術機関と研究者が共同した、基盤研究の大規模な業績が出版された。
5. モンゴル研究の業績と学術会議報告の水準を上げ、要求する基準を満たした業績が出るようになり、会議において資金援助を得られるようになったことにより、この方面での活動において質的な進歩が生じた。
6. モンゴル研究活動が統一的構造に取り込まれ、内外における研修・研究機関と研究者の力を合わせて大規模な業績を著し、学術会議を組織することに注力するようになった。
7. 外国のモンゴル研究機関の活動が強化され、地位を保全することにおいて、モンゴル国政府が実行しているモンゴル研究支援策が一定の刺激を与えた。
8. モンゴル研究を発展させる施策が一定の方向性を持つようになり、今後、この方向の活動を一層強化する可能性が整った。